



**МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр

№ 01

Улаанбаатар хот

**Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх
Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, Монголын цахилгаан холбоо ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8.7 дахь заалт, 2022 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг зөвшөөрч баталсугай.

ХУРЛЫН ДАРГА

С.НЯМБАЯР

**МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр

№ 02

Улаанбаатар хот

**Компанийн 2021 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын
дүгнэлтийг батлах тухай**

Компанийн тухай хуулийн 96 дугаар зүйлийн 96.5 дахь хэсэг, Монголын цахилгаан холбоо ХК-ийн дүрмийн 7.8.7 дахь заалт, 2022 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2021 оны санхүүгийн тайлан тэнцлийг дор дурдсанаар баталсугай:

1.1. Нийт хөрөнгийг 42,994,251,135.04 (дөчин хоёр тэрбум есөн зуун ерэн дөрвөн сая хоёр зуун тавин нэгэн мянга нэг зуун гучин таван) төгрөгөөр, үүнээс эргэлтийн бус хөрөнгийг 31,426,879,394.41 (гучин нэгэн тэрбум дөрвөн зуун хорин зургаан сая найман зуун далан есөн мянга гурван зуун ерэн дөрвөн) төгрөгөөр;

1.2. Өр төлбөрийн нийт дүнг 8,501,803,844.32 (найман тэрбум таван зуун нэгэн сая найман зуун гурван мянга найман зуун дөчин дөрвөн) төгрөгөөр;

1.3. Эзэмшигчийн өмчийг 34,492,447,290.72 (гучин дөрвөн тэрбум дөрвөн зуун ерэн хоёр сая дөрвөн зуун дөчин долоон мянга хоёр зуун ерэн) төгрөгөөр тус тус баталсугай.

2. Монголын цахилгаан холбоо ХК-ийн хараат бус аудитын байгууллагаар хийлгэсэн аудитын тайлан, дүгнэлтийг зөвшөөрсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



С.НЯМБАЯР



**МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр

№ 03


Улаанбаатар хот

**ТУЗ-ийн Аудитын хорооны санхүүгийн тайлангийн талаарх
дүгнэлтийг батлах тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.14, 62.1.1 дахь заалт, Монголын цахилгаан холбоо ХК-ийн дүрмийн 7.8.7 дахь заалт, 2022 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хорооны дүгнэлтийг зөвшөөрч баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



С.НЯМБАЯР

**МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр

№ 04


Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг чөлөөлж, сонгох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, Монголын цахилгаан холбоо ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8.6, 7.10, 7.16, 7.18 дахь заалт, 2022 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монголын цахилгаан холбоо ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд нэр дэвшигчдээс кумулятив аргаар хамгийн олон санал авсан А.Молорыг Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр Ц.Норовжамц, Ж.Тамир, Ю.Бат-Эрдэнэ нарыг Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдрөөс тус тус сонгосугай.
2. Ц.Шинэхүүг Монголын цахилгаан холбоо ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүний үүрэгт ажлаас 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдрөөр тасалбар болгон тус тус чөлөөлж, бүрэн эрхийг нь дуусгавар болгосугай.
3. Компанийн үйл ажиллагааг үр ашигтай удирдан зохион байгуулж, холбогдох хууль, дүрэм, журмын дагуу ажиллахыг сонгогдсон Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



С.НЯМБАЯР



**МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр № 05

Улаанбаатар хот

ТУЗ-ийн 2022 оны зардлын төсвийг батлах тухай


Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалт, Монголын цахилгаан холбоо ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8.6 дахь заалт, 2022 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монголын цахилгаан холбоо ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны зардлын төсвийг Хавсралтаар баталсугай.
2. Батлагдсан төсвийн зарцуулалтад хяналт тавьж, зардал хэтрүүлэхгүй, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалинг түүний ажлын үр дүнг харгалзан олгож байхыг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргад үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



С.НЯМБАЯР



ТУЗ-ИЙН 2022 ОНЫ ЗАРДЛЫН ТӨСӨВ

/Нэгж: төгрөг/

№	Зардлын төрөл	Тоо	Нэгж зардал	Давтамж	Нийт дүн
1. Цалин, холбоо, тээврийн зардал					
1	ТУЗ-ийн гишүүний цалин	9	805,000	12	86,940,000
2	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга	1	620,000	12	7,440,000
3	ТУЗ-ийн нарийн бичгийн даргын холбоо, тээврийн зардал	1	150,000	12	1,800,000
Цалин, холбоо, тээврийн зардлын дүн					96,180,000
4	Нийгмийн даатгалын шимтгэл				12,984,300
Дэд дүн					109,164,300
2. Бичиг хэрэг, хурлын зардал					
1	Бичиг хэрэг, хэвлэмэл материал, цай, кофены зардал	1	150,000	12	1,800,000
2	ТУЗ-ийн хэрэгцээнд зөөврийн компьютер, дуу хураагч авах, (CPU: 10th Generation Intel® Core™ i7 processor, RAM: 16GB HDD: 512GB)	1	5,000,000	1	5,000,000
3	Хурал зохион байгуулах байрны түрээс	1	200,000	4	800,000
4	Бусад зардал	1	110,000	6	660,000
Дэд дүн					8,260,000
3. ХХМТ-ийн салбар болон дэд бүтэц, бусад холбогдох салбарын туршлага судлах, хурал, үзэсгэлэнд оролцох, сургалтын зардал					
1	Тээврийн зардал	5	2,500,000	1	12,500,000
2	Зам хоног /5 өдөр/	5	145,000	5	3,625,000
3	Зочид буудал /5 өдөр/	5	435,000	5	10,875,000
Дэд дүн					27,000,000
Нийт дүн					144,424,300

Тайлбар: Төсөв 2022 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас дараа (2023) оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хүртэл хугацаанд хамаарна.

**МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр

№ 06

Улаанбаатар хот

Үл хөдлөх хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.15, 62.1.16 дахь хэсэг, Засгийн газрын 2020 оны 10 дугаар тогтоол, “Монголын цахилгаан холбоо” хувьцаат компанийн дүрмийн 7.1 дэх заалт, 2022 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь;

1. “Монголын цахилгаан холбоо” хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 261,398,226.52 (хоёр зуун жаран нэгэн сая, гурван зуун ерэн найман мянга, хоёр зуун хорин зургаан) төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.


2. “Монголын цахилгаан холбоо” хувьцаат компанийн Гүйцэтгэх захирал (Б.Чинбат)-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Компанийн Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор барилгыг акталж, данснаас хасах, хоёрдогч түүхий эд болгон ашиглах буюу худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Компанийн үл хөдлөх хөрөнгийг буулгаж, чөлөөлсөн газрыг “Монголын цахилгаан холбоо” хувьцаат компанийн оффиссын болон үйлчилгээний зориулалтаар ашиглах, газрыг нөхөн сэргээх;

3. Энэхүү тогтоолыг хэрэгжүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Б.Чинбат)-д, хэрэгжилтэд хяналт тавьж, тайланг Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулахыг Төлөөлөн удирдах зөвлөл (Т.Лхагвасүрэн)-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



С.НЯМБАЯР